



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 02 дугаар сарын 16

Дугаар A/19

Баян-Өндөр сум

**Ээлжит хуралдааны
товыг өөрчлөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын орлогчоос ирүүлсэн хүсэлтийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн Ээлжит XVIII хуралдааныг 2023 оны 02 дугаар сарын 29-ний өдөр болгон өөрчилж, дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр тогтоосугай.

- 1.1. "Орон нутгийн өмчит зарим байгууллагуудын дүрэм, бүтэц орон тоонд нэмэлт өөрчлөлт оруулах" тухай
- 1.2. "Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварын хэмжээг шинэчлэн тогтоох" тухай
- 1.3. "Журмын хашааны төлбөрийн хэмжээг тогтоох" тухай
- 1.4. "Цагаан тоосны дэгдэлт сөрөг нөлөөллийг бууруулах" хөтөлбөр батлах тухай
- 1.5. "Жендерийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлсэн ажлын биелэлтийн" тухай
- 1.6. Тогтоол хүчингүй болгох тухай
- 1.7. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн гишүүдийг шинэчлэн батлах тухай
- 1.8. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Хороодын бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит XVIII хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Тус захирамж батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/15 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ

6179130042

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
даргын 2024 оны 02 дугаар сарын 16-ны
өдрийн 2/19 дугаар захирамжийн хавсралт

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ XVIII ХУРАЛДААНЫ БЭЛТГЭЛ ХАНГАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит XVIII хуралдааныг зарласан тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг мэдээллээр хангах;

II/16-ны дотор

Ажлын алба

2.“Орон нутгийн өмчит зарим байгууллагуудын дүрэм, бүтэц орон тоонд нэмэлт өөрчлөлт оруулах” тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

II/19, II/21, II/29-ний дотор

Аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал

3.“Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварын хэмжээг шинэчлэн тогтоох” тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

II/19, II/21, II/29-ний дотор

Аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал

4. “Журмын хашааны төлбөрийн хэмжээг тогтоох” тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

II/19, II/21, II/29-ний дотор

Аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал

5. “Цагаан тоосны дэгдэлт сөрөг нөлөөллийг бууруулах” хөтөлбөр батлах тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

II/19, II/21, II/29-ний дотор

Аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал

6. Жендерийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлсэн ажлын биелэлтийн тухай асуудлын илтгэл, тайланг Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

II/19, II/21, II/29-ний дотор

Аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал

7.“Тогтоол хүчингүй болгох” тухай асуудлын илтгэл, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

II/19, II/21, II/29-ний дотор

Аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал

8. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн гишүүдийг шинэчлэн батлах тухай асуудлын асуудлын шийдвэрийн төсөл, танилцуулгыг боловсруулж Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

II/19, II/21, II/29-ний дотор Аймгийн ИТХ-ын БХИОХ

9. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Хороодын бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай асуудлын шийдвэрийн төсөл, танилцуулгыг боловсруулж Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

II/19, II/21, II/29-ний дотор Аймгийн ИТХ-ын БТХЭЗХ

10.Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан холбогдох Хороод ажиллаж санал дүгнэлт гаргах;

II/27-ны дотор Холбогдох Хороод

11.Техник зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангах;

II/29-ны дотор Ажлын албаны дарга Б.Ганзориг

АЖЛЫН АЛБА